

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН 2014 ОНЫ
02 ДУГААР УЛИРЛЫН ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ
МЭДЭЭ, САНХҮҮГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2014.8.05

Улаанбаатар хот

НЭГ. ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭНИЙ ИРЦ

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.1 дэх заалтыг үндэслэн “Валютын арилжааг цэгцтэй болгох зорилгоор зарим тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 02 дугаар сарын 28 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-д 7 заалт бүхий 2.6 дахь хэсгийг болон гадаад валютын арилжааны мэдээ гаргах хавсралтуудыг тус тус шинээр нэмж, “Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа” эрхлэн явуулдаг банк бус санхүүгийн байгууллага /цаашид ББСБ гэх/-ууд эдгээр хавсралтын дагуу мэдээг дараа сарын 10-ны өдрийн дотор гаргаж, Хороонд ирүүлж байхыг заасан. Үүний дагуу гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудаас гадаад валютын арилжааны мэдээг сар бүр гаргуулан авч, улирлаар нэгтгэн Хорооны удирдлагуудад танилцуулж, нэгтгэлийг товч байдлаар Монголбанкинд хүргүүлж байгаа болно.

Манай улсын хэмжээнд 2014 оны 6 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэн явуулж буй 326 ББСБ байгаагийн 118 ББСБ нь буюу нийт ББСБ-ын 36.2 хувь нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна.

Үүнээс 50 ББСБ нь зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа бөгөөд нийт 326 ББСБ-ын 15.33 хувийг эзэлж, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт 118 ББСБ-ын 42.4 хувийг эзэлж байна.

Харин 68 ББСБ нь энэхүү үйл ажиллагааг банк бус санхүүгийн бусад үйл ажиллагаатай давхар эрхлэх зөвшөөрөлтэй байна.

Тайлант хугацаанд гадаад валютын арилжааны мэдээ ирүүлбэл зохих нийт 118 ББСБ-ын 73 нь ирүүлж, 45 нь ирүүлээгүй бөгөөд мэдээний ирц 61.9 хувьтай байна.

Мэдээ ирүүлээгүй 45 ББСБ-ын 32 нь тайлант хугацаанд энэхүү үйл ажиллагааг эрхлэн явуулаагүй, цаашид явуулна гэсэн тайлбар бүхий албан бичгийг Хороонд ирүүлсэн бөгөөд 8 ББСБ нь шинээр тусгай зөвшөөрөл авсан, 5 ББСБ нь ямар нэгэн тайлбар ирүүлээгүй байна.

Мэдээний ирцийг өмнөх улирлуудтай харьцуулан үзвэл:

/Хүснэгт 1/

д/д	ҮЗҮҮЛЭЛТ	Мэдээ ирүүлэх ББСБ-ын тоо	Мэдээ ирүүлсэн ББСБ-ын тоо	Мэдээний ирц	Өсөлт, бууралт хувиар /өмнөх улирлаас /
1	2011 оны 1 дүгээр улирал	93	73	78.5%	0.0%
2	2011 оны 2 дугаар улирал	98	60	61.2%	-17.3%
3	2011 оны 3 дугаар улирал	96	52	54.2%	-7.0%
4	2011 оны 4 дүгээр улирал	92	67	72.8%	18.6%
5	2012 оны 1 дүгээр улирал	91	68	74.7%	3.0%
6	2012 оны 2 дугаар улирал	91	66	72.5%	-2.2%
7	2012 оны 3 дугаар улирал	91	61	67.0%	-5.5%
8	2012 оны 4 дүгээр улирал	94	68	72.3%	5.3%
9	2013 оны 1 дүгээр улирал	98	70	71.4%	-0.9%
10	2013 оны 2 дугаар улирал	98	69	70.4%	-1%
11	2013 оны 3 дугаар улирал	99	64	67.67%	-2.33%
12	2013 оны 4 дүгээр улирал	104	74	71.15%	3.48%
13	2014 оны 1 дүгээр улирал	111	73	65.76%	-5.39%
14	2014 оны 2 дугаар улирал	118	73	61.9%	-3.86%

Дээрх хүснэгтээс тайлант хугацаанд валютын арилжааны мэдээний ирцийг хувиар тооцож үзвэл:

- 2010 оны 1,2,3,4 дүгээр улиралд 27.7% -с 74.7%;
- 2011 оны 1,2,3,4 дүгээр улиралд 54.2% -с 78.8%;
- 2012 оны 1,2,3,4 дүгээр улиралд 67.0% -с 74.7%;
- 2013 оны 1 дүгээр улиралд 71.4%;
- 2013 оны 2 дугаар улиралд 70.4%;
- 2013 оны 3 дугаар улиралд 67.6%;
- 2013 оны 4 дүгээр улиралд 71.15%;
- 2013 оны 1,2,3,4 дүгээр улиралд 67.6% -с 71.15%;
- 2014 оны 1,2 дугаар улиралд 61.9%-65.76% байна.

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа идэвхтэй эрхлэн явуулж буй ББСБ-уудын хувьд мэдээгээ 100 хувь ирүүлж байгаа бөгөөд зарим ББСБ-уудын хувьд гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэхгүй байгаа тухай албан бичгийг сар бүр ирүүлж байна. Эдгээр ББСБ-уудын үйл ажиллагаа идэвхжээгүй тохиолдолд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журмын 10.1.3'-д заасны дагуу холбогдох арга хэмжээ авах үндэслэл бүрдэх болохыг мэдэгдэн ажиллаж байна.

Хороо 2014 оны 02 дугаар улиралд нийт 8 ХХК-д гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосноос 7 ХХК-д зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, 1 ХХК-д гадаад валютын арилжааны үйл ажиллагааг бусад үйл ажиллагаатай давхар эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.

ХОЁР. ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖАА БОЛОН ВАЛЮТЫН ХАНШ

ББСБ-уудаас ирүүлсэн гадаад валютын арилжааны мэдээнд үндэслэн иргэн, хуулийн этгээдээс худалдан авсан гадаад валютууд болон худалдсан гадаад валют тус бүрийн ханшийг ам.доллар болон Монгол улсын үндэсний валют төгрөгт хөрвүүлсэн дүнгээр тус тус тооцон өмнөх улиралтай харьцуулсан байдлаар гаргалаа.

2.1 Гадаад валютыг худалдан авсан болон худалдсан арилжааны талаар:

Тайлант хугацаанд гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх 118 ББСБ-уудын худалдан авсан болон худалдсан валютуудын дүнг ам.доллар, төгрөгт хөрвүүлэн, өмнөх улиралтай харьцуулж үзвэл:


Худалдан авсан:

/Хүснэгт 2/

№	ВАЛЮТЫН НЭР	Жил				
		2013 оны 10,11,12 дугаар сар	2014 оны 1, 2, 3 дугаар сар	Өсөлт, бууралт /+;-/ /өмнөх үеэс/	2014 оны 4, 5, 6 дугаар сар	Өсөлт, бууралт /+;-/ /өмнөх үеэс/
1	Төгрөгт шилжүүлсэн /мянган төгрөгөөр/	307,622,338.9	235,176,339.9	-72,448,999.0	301,205,463.6	66,029,123.7
2	Ам.долларт шилжүүлсэн /мянган ам.доллар/	181,360.9	135,374.1	-45,986.8	166,992.8	31,618.7
3	ДУНДАЖ ХАНШ	1,696.19	1,737.23	41.04	1,803.7	66.47

Худалдан авсан валютуудыг төгрөгт шилжүүлснээр /мян.төг/:

/График1/




Худалдсан:

/Хүснэгт 3/

№	ВАЛЮТЫН НЭР	Жил				
		2013 оны 10,11,12 дугаар сар	2014 оны 1, 2, 3 дугаар сар	Өсөлт, бууралт /+-/-/өмнөх үгэс/	2014 оны 4, 5, 6 дугаар сар	Өсөлт, бууралт /+-/-/өмнөх үгэс/
1	Төгрөгт шилжүүлсэн /мянган төгрөгөөр/	299,610,901.16	228,652,873.16	-70,958,028.0	300,357,469.03	71,704,595.87
2	Ам.долларт шилжүүлсэн /мянган ам.доллар/	175,419.54	130,856.52	-44,563.02	165,864.86	35,008.34
3	ДУНДАЖ ХАНШ	1,707.97	1,747.36	39.39	1,810.86	63.5

Худалдсан валютуудыг төгрөгт шилжүүлснээр /мян.төг/:

/График 2/




Тайлант улиралд худалдан авсан нийт гадаад валютуудын дүнг төгрөгт хөрвүүлэн, өмнөх улиралтай харьцуулахад 66,029,123.7 мянган төгрөгөөр буюу 28.1 хувиар, ам.долларт хөрвүүлсэн дүнгээр 31,618.7 мянган ам.доллараар буюу 23.4 хувиар тус тус өссөн байна. Худалдсан нийт гадаад валютуудын хувьд өмнөх улиралтай харьцуулахад 71,704,595.87 мянган төгрөгөөр буюу 31.3 хувиар, ам.долларт хөрвүүлсэн дүнгээр 35,008.34 мянган ам.доллараар буюу 26.7 хувиар тус тус өссөн байна.

ББСБ-уудын 2014 оны 02 дүгээр улиралд худалдсан нийт гадаад валют болон худалдан авсан нийт гадаад валютуудын дүнг төгрөгт шилжүүлснээр /300,357,469.03₮-301,205,463.6₮/ -847,994.57 мянган төгрөг буюу нийт арилжааны үнийн дүнгийн 0.14 хувийг, ам.долларт хөрвүүлснээр /165,864.86\$-166,992.8\$/ -1,127.9 мянган ам.доллар буюу 0.33 хувийг тус тус эзэлж байна. Өөрөөр хэлбэл, тайлант хугацаанд ББСБ-уудаас валютын зах зээлд нийлүүлэх гадаад валютын нийлүүлэлтийн хэмжээ өссөн байна.

Нэгтгэлийн дүнгээр худалдан авсан нийт валютын 2.89 хувийг хуулийн этгээдээс, 97.1 хувийг иргэдээс худалдан авсан, худалдсан нийт валютын 2.5 хувийг хуулийн этгээдэд, 97.5 хувийг иргэдэд худалдсан байх ба энэ нь ББСБ-уудын гадаад валютын арилжаанд ихэвчлэн иргэд үйлчлүүж байгаа болохыг харуулж байна.


Хуулийн этгээдээс худалдан авсан валютуудын дүн /мянгачилсан дүнгээр/:

График 3/




Хуулийн этгээдэд худалдсан валютуудын дүн /мянгачилсан дүнгээр/:

График 4/




Иргэдээс худалдан авсан валютуудын дүн /мянгачилсан дүнгээр/:

График 5/



Иргэдэд худалдсан валютуудын дүн /мянгачилсан дүнгээр/:

График 6/




2.2 Валютын ханшны талаар:

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх 118 ББСБ-ын худалдан авсан болон худалдсан нийт валют тус бүрийн дундаж ханшийг харуулбал:


Гадаад валютуудыг худалдан авсан дундаж ханш:

График 7/



Гадаад валютуудыг худалдсан дундаж ханш:

График 8/



ББСБ-уудын гадаад валютын арилжаанд түгээмэл ордог гадаад валютуудын зах зээл дэх ханшийн өөрчлөлт /хэлбэлзэл/-ийг үзүүлбэл:

/төгрөгөөр/

/Хүснэгт 4/

№	Валютын төрөл	Худалдаж авсан дундаж ханш				Өсөлт, бууралт /+;- /өмнөх үеэс/
		2013 оны 10,11,12-р сар	2014 оны 1, 2, 3 дугаар сар	Өсөлт, бууралт /+;- /өмнөх үеэс/	2014 оны 4, 5, 6 дугаар сар	
1	АНУ доллар	1,696.19	1,737.23	41.04	1,803.7	66.47
2	Евро	2,310.69	2,391.79	81.1	2,471.74	79.95
3	БНХАУ-ын юань	279.11	285.63	6.52	289.69	4.06
4	ОХУ-ын рубль	51.36	49.21	-2.15	51.21	2.0
5	Японы иен	16.79	16.95	0.16	17.48	0.53

/төгрөгөөр/


/Хүснэгт 5/

№	Валютын төрөл	Худалдсан дундаж ханш				Өсөлт, бууралт /+;- /өмнөх үеэс/
		2013 оны 10,11,12-р сар	2014 оны 1, 2, 3 дугаар сар	Өсөлт, бууралт /+;- /өмнөх үеэс/	2014 оны 4, 5, 6 дугаар сар	
1	АНУ доллар	1,707.97	1,747.36	39.39	1,810.86	63.5
2	Евро	2,333.38	2,412.07	78.69	2,488.32	76.25
3	БНХАУ-ын юань	282.33	287.76	5.43	290.91	3.15
4	ОХУ-ын рубль	52.36	50.14	2.22	51.97	1.83
5	Японы иен	17.14	17.17	0.03	17.81	0.64

Гадаад валютын арилжааны мэдээний нэгтгэлээс үзэхэд тайлант хугацаанд нийт /300,357,469.0₮+301,205,463.6₮/ 601,562,932.6 мянган төгрөг буюу /165,864.9\$+166,992.8\$/ 332,857.7 мянган ам.долларын арилжаа хийсний /130,259,770.4₮+133,246,495.5₮/ 263,506,265.9 мянган төгрөг буюу /71,932.7\$+73,873.8\$/ 145,806.5 мянган ам.доллар нь нийт арилжааны 43.8 хувийг, /14,814,804.8₮+12,901,822.1₮/ 27,716,626.9 мянган төгрөг буюу /8,181.1\$+7,152.9\$/ 15,334.0 мянган ам.долларын евро нь нийт арилжааны 4.6 хувийг, /138,663,893.9₮+139,118,331.8₮/ 277,782,225.7 мянган төгрөг буюу /77,129.6\$+76,573.6\$/ 153,703.2 мянган ам.долларын юань нийт арилжааны 46.2 хувийг юань эзэлж байгаа бөгөөд үлдсэн 5.4 хувийг бусад валют эзэлж байна.

Нийт гадаад валютуудын арилжаанд тухайн валютын эзлэх хувь:

/График 9/



2.3 Гадаад валютын арилжаа эрхэлдэг ББСБ-уудын санхүүгийн тайлангийн товч үзүүлэлтийн талаар:

2014 оны 6 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Хорооноос тусгай зөвшөөрөл авсан нийт 326 ББСБ байгаагийн 118 ББСБ буюу 36.2 хувь нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгаагийн дотор 50 ББСБ нь зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг дагнан эрхлэх зөвшөөрөлтэй байна. Тэдгээрийн нийт актив нийт ББСБ-ын активын 52.1 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 49.8 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 45.5 хувийг тус тус эзэлж байна.

Гадаад валютын арилжаа эрхэлдэг ББСБ-уудын 2014 оны 02 дугаар улирлын санхүүгийн тайлангийн товч үзүүлэлт /мян.төг/:

/Хүснэгт 6/

№	Үндсэн үзүүлэлтүүд	Зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй ББСБ-ууд	Гадаад валютын арилжааны үйл ажиллагааг банк бус санхүүгийн бусад үйл ажиллагаатай давхар эрхлэх зөвшөөрөлтэй ББСБ-ууд	Нийт гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ууд
	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	50	68	118
	ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь	15,3%	20,9%	36,2%
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	10 034 793,58	220 780 224,09	230 815 017,66
	ББСБ-ын нийт активт эзлэх хувь	2,3%	49,8%	52,1%
Б	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	9 956 750,07	128 913 082,76	138 869 832,83
	ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь	3,6%	46,2%	49,8%
В	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	8 339 242,37	92 504 506,05	100 843 748,42
	ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь	3,8%	41,8%	45,5%
Г	Нийт орлого	728 500 267,09	34 797 914 441,53	35 526 414 708,62
Д	Нийт зарлага	669 384 372,41	24 600 929 356,29	25 270 313 728,71
Е	Ашиг/алдагдал	59 115 894,68	10 196 985 085,24	10 256 100 979,91

Гадаад валютын арилжааны үйл ажиллагааг банк бус санхүүгийн бусад үйл ажиллагаатай давхар эрхлэх зөвшөөрөлтэй 68 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 20.9 хувийг, тэдгээрийн нийт актив нийт ББСБ-ын активын 49.8 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 46.2 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 41.8 хувийг тус тус эзэлж байна.

Гадаад валютын арилжаа дангаар эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 50 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 15.3 хувийг, тэдгээрийн нийт актив нийт ББСБ-ын активын 2.3 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 3.6 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 3.8 хувийг тус тус эзэлж байна.

ГУРАВ. САНАЛ, ДҮГНЭЛТ

Тайлант хугацаанд гадаад валютын арилжааны мэдээ ирүүлбэл зохих нийт 118 ББСБ-аас 73 нь мэдээгээ ирүүлж, 40 нь үйл ажиллагаа явуулаагүй тухай албан бичиг ирүүлж, 5 ББСБ ямар нэгэн тайлбар ирүүлээгүй байна.

Мэдээний ирц 2011 оны 1,2,3,4 дүгээр улиралд 54.2% -с 78.8%, 2012 оны 1,2,3,4 дүгээр улиралд 67.0% -с 74.7%, 2013 оны 1,2,3,4 дүгээр улиралд 67.6% -с 71.15%, 2014 оны 1,2 дугаар улиралд 61.9%-65.76% байна. Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлээгүй тухай албан бичиг ирүүлсэн ББСБ-уудын тоог оруулан тооцвол 2014 оны 2 дугаар улиралд ирц 95.7%-тай байна. Сүүлийн үед ханшийн хэлбэлзлийн улмаас гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэхгүй байгаа ББСБ-ууд нэмэгдэж байна.

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа идэвхтэй эрхлэн явуулж буй ББСБ-уудын хувьд мэдээгээ 100 хувь ирүүлж байгаа бөгөөд зарим ББСБ-уудын хувьд гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэхгүй байгаа тухай албан бичгийг сар бүр ирүүлж байна. Эдгээр ББСБ-уудын үйл ажиллагаа идэвхжээгүй тохиолдолд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журмын 10.1.3'-д заасны дагуу холбогдох арга хэмжээ авах үндэслэл бүрдэх болохыг мэдэгдэн ажиллаж байна.

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлдэг ББСБ-ууд нь гадаад валютын ханшийн зөрүүн дээр ашиг олох зорилготой байдагтай уялдан ББСБ-уудын мөнгөн хөрөнгө зах зээл дээрх эрэлт хэрэгцээтэй уялдан өдөрт хэдэн ч удаа эргэлтэд орох тохиолдол гардаг. Иймээс гадаад валютын худалдсан болон худалдан авсан мөнгөний дүн өндөр дүнтэй гардаг.

2014 оны 2 дугаар улиралд худалдан авсан болон худалдсан нийт гадаад валютуудын хувьд өмнөх онтой харьцуулахад төгрөгт хөрвүүлсэн дүн, ам.долларт хөрвүүлсэн дүнгээр аль алингаар нь өссөн үзүүлэлттэй байна. Улирлын шинж чанараас шалтгаалан юанийн хувьд худалдан авсан болон худалдсан арилжааны дүн эрс өссөн үзүүлэлттэй байна. Мөн тайлант хугацаанд гадаад валютуудыг худалдсан дүн худалдан авсан дүн ойролцоо байгаа нь ББСБ-ууд худалдан авсан валютаа эргээд бүгдийг нь худалдаж байгаа дүр зураг ажиглагдаж байна. Энэ нь валютын нөөц багасч байгаа, мөн валютын эрэлт хэрэгцээ их байгаатай холбон тайлбарлаж болохоор байна.

2014 оны 4,5,6 дугаар сард Монголбанкнаас зарласан ам.долларын албан ханшны хамгийн өндөр дүн нь 1,826.56 төгрөг байсан бол ББСБ-уудын хувьд 1,829.0 төгрөгөөр худалдан авч 1,832.0 төгрөгөөр худалдсан нь өмнө нь хүрч байгаагүй хамгийн өндөр дүн байлаа.

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт ББСБ-уудыг арилжааны мэдээгээ сар бүр, бүрэн цахим хэлбэрээр ирүүлж байхыг хариуцсан хянан шалгагч нар нь утсаар ярьж, шаардан цахим болон хэвлэмэл хэлбэрээр авч байна. Өмнөх онуудтай харьцуулахад ББСБ-ууд тогтмол мэдээгээ ирүүлж хэвшиж байгаа сайн үр дүн харагдаж байна.

Мэдээг цахим хэлбэрээр ирүүлсэн ББСБ-уудын тоог авч үзвэл:

/Хүснэгт 7/

№	Хугацаа	Ирц /ББСБ тоогоор/
1	2011 оны 8 дугаар сар	15
2	2011 оны 9 дүгээр сар	12
3	2011 оны 10 дугаар сар	31
4	2011 оны 11 дүгээр сар	41
5	2011 оны 12 дугаар сар	39
6	2012 оны 1 дүгээр улирал	36
7	2012 оны 2 дугаар улирал	34
8	2012 оны 3 дугаар улирал	31
9	2012 оны 4 дүгээр улирал	69
10	2013 оны 1 дүгээр улирал	70
11	2013 оны 2 дугаар улирал	69
12	2013 оны 3 дугаар улирал	64
13	2013 оны 4 дүгээр улирал	70
14	2014 оны 1 дүгээр улирал	73
15	2014 оны 2 дугаар улирал	73

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэн явуулдаг ББСБ-ууд нь бэлэн мөнгөөр арилжаа хийдэг учраас гадаад валютын арилжааны мэдээг бүх ББСБ-уудаар сар бүр, бүрэн гаргуулан авч, нэгтгэлд хамруулж байх нь мөнгө санхүүгийн зах зээл дээр эргэлдэж буй бэлэн мөнгөний тоо хэмжээг тодорхой гаргахад чухал ач холбогдолтой.

Мэдээний ирц, үнэн бодит байдал нь мөнгө санхүүгийн зах зээл дээр арилжаалагдаж буй гадаад валютын нэр төрөл түүний тоо хэмжээ, ханш, ханшийн хэлбэлзэлийн талаарх мэдээллийг тодорхой харуулах юм. Энэ нь гадаад валютын ханшийн өөрчлөлтүүд манай улсын үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшид хэрхэн нөлөөлж буй эсэхийг тодорхойлоход төдийгүй мөнгөний бодлогод чухал үүрэг гүйцэтгэнэ.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР